

АХУЙ БА БАЙГААГИЙН ТУХАЙ М.ХАЙДЕГГЕРИЙН ҮЗЭЛ

Ц.ГОМБОСҮРЭН
МУИС, НШУС, Философийн тэнхим

Түлхүүр үг: Ахуй. Байгаа. Энэ-ахуй. Ман. Цаг хугацаа. Санаашрал. Санаашралын элементүүд. Ахуйн утгыг илрүүлэх арга. "Европын метафизик" гэдэг М.Хайдеггерийн ойлголт. Европын метафизикийн талаархи М.Хайдеггерийн шүүмжлэл.

Ахуйн тухай сургаал бол сонгодог философийн хамгийн цөм асуудал болж иржээ. Гагцхүү XIX зууны 30-40-өөд оноос хойш үүссэн позитивизм зэрэг сонгодог биш философийн янз бүрийн чиглэлүүд сонгодог онтологийг түүхийн хувьд үеэ өнгөрөөсөн сэтгэлгээ мөн гэж зарлах болсон билээ. Хэдий тийм боловч сонгодог онтологи эдүгээ хүртэл оршин тогтнолоо хадгалж ирсэн юм. Үүний хамт сонгодог биш философийн олон чиглэл өөр өөрийн өвөрмөц онтологи баримтлал боловсруулсан билээ. Онтологийг философиос хөөх тухай үзэл XX зууны туршид гарч ирсэн боловч тийнхүү онтологи янз бүрийн сургаал оршин тогтносоор байгаа юм. Гэхдээ энэ миний үг бол аль нэг юм уу зарим хэдэн онтологи сургаалыг нь хамгаалах, эсвэл үгүйсгэх зорилготой биш, харин философийн амьдрал дахь бодит баримтыг дурдаж буй байдал мөн.

Сонгодог биш онтологийг авч үзэж буй үед М.Хайдеггерийн метафизикийг онцлох шаардлагатай байдаг. Учир нь, онтологи асуудал XIX зууны сүүлийн хагасаас философийн асуудлуудын арын эгнээнд шилжсэн байсныг М.Хайдеггер урагш нь татан гаргаж, түүнийг философийнхоо төв асуудал болгосон аж. М.Хайдеггерийн ийм үйл ажиллагаа нь тэрээр философийн түүхэн дэх хөлбогдох гол гол онол, арга зүйг нягтлан судалж, үзэлэлт, дүгнэлт өгсний үр дүн болж байдаг. Тэрээр 1907 онд, шашны гимназид сурч байсан 18 насандаа австрийн философич Ф.Брентано (1838-1917)-гийн бичсэн "Аристотелийн хувьд байгаа бол олон утгатай нь" гэдэг диссертацийн зохиолыг бэлгэнд авчээ. Чухамхүү энэ бүтээлийг судалсан нь М.Хайдеггер философи руу нэвтрэх, тэхдээ онтологи асуудал руу орох хөтөч болж өгсөн тухай тэрээр өөрөө дурссан байдаг аж¹ (см. об этом: Н.А.Гучинская. Вместо предисловия. Стрекало вопроса.-Мартин Хайдеггер. Введение в философию. Пер.с нем. Н.О.Гучинской. СПб., 1997, с.17)

М.Хайдеггерийн философи боловсруулалтын нэг чухал талбар нь Аристотелийн метафизикт хийсэн шинжилгээ байжээ.

Аристотелийн хувьд оюуны мэдлэг бол физик, математик, анхдагч философи гуравт хуваагддаг. Эдгээрээс физик нь хөдлөх чадвартай байгааг, математик нь хөдлөх чадваргүй байгааг тус тус судалдаг бол анхдагч философи нь хөдөлгөөнгүй бөгөөд бие даасан оршигчийг судалдаг. Анхдагч философийг бас мөн чанарын тухай, өөрөөр хэлбэл юмын ахуйн мөн чанарын тухай шинжлэх ухаан гэж болно хэмээн Аристотель бичсэн байдаг. Үүнд: анхдагч философи бол байгааг тиймээр нь, бас байгаад бидэнд хүртээлгүйгээр буй зүйлийг судалдаг шинжлэх ухаан мөн гэж Аристотель үзсэн юм.

Гэхдээ эртний Грекийн ганц Аристотель биш, бас Платон болон тэднээс өмнөх үеийн зарим сэтгэгч ахуй, оршихуйн асуудлыг ярихдаа объективист байрнаас ханджээ. Үүнийг Аристотельд холбогдуулж М.Хайдеггер бичихдээ: "...метафизик бол тодорхой бүрэн мөн чанарлаг утгаараа "физиик мөн"² (Мартин Хайдеггер. О существе и понятии Аристотель "Физика". -1. М., 1995, 30 дахь тал) гэсэн байдаг. Харин М.Хайдеггер бол өөрийн боловсруулсан метафизиктээ Аристотелийн болон бусад грекчүүдийн объективизмыг дагаагүй аж. Гэхдээ тэрээр эртний грекчүүдийн онтологи үзлийг илэрхийлсэн нэр томъёонуудыг ашиглаж, ингэхдээ тэдгээрийг субъективист агуулга, арга зүйлд нийцүүлсэн утгатай болгожээ.

М.Хайдеггер "ахуй" гэдэг ойлголтоос гадна "байгаа" гэдэг ойлголтыг өөрийнхөө боловсруулсан "фундаменталь онтологид" үндсэн категори болгон оруулсан байна. Энэ нь угтаа Аристотелиос эх сурвалжтай нь М.Хайдеггерийн бүтээлүүдээс анзаарагддаг.

М.Хайдеггерийн анхан үеийн философи үйл ажиллагаа аргазүйн хувьд Э.Гуссерлийн феноменологийн шууд нөлөөнд өрнөж байжээ. Гэхдээ М.Хайдеггер анхнаасаа Гуссерлийг залгамжлагч төдийгүй бие даасан сэтгэгч байсан хэмээн судлаачид тэмдэглэсэн байдаг³ (см. об этом напр.: А.Михайлов. Место введения.- Мартин Хайдеггер. Работы и размышления разных лет. Пер. с нем. А.Михайлова. М., 1993, с. XXXI).

Судлаачид М.Хайдеггерийн эрдэм номын намтрыг гаргах тодорхой ажил хийж ирснээс үзвэл католик теологийн боловсролыг 20-иод насандаа эзэмшсэн тэрээр уран зохиол, түүний дотор яруу найраг, философийн бүтээлүүдийг шимтэн уншиж, судлах болж, улмаар христос шашныг бүхэлд нь үгүйсгээгүй ч гэсэн түүний католик тогтолцооноос 30 насныхаа үед буюу

1919 оны эхээр бүрэн татгалзаж, философи үйл ажиллагаа тууштай эрхлэх болсон байна. Энэхүү 1919 он бол М.Хайдеггер Фрейбургийн их сургуульд Э.Гуссерлийн ассистент болсон жил аж. Улмаар тэрээр Аристотелийн онтологийг феноменологи сэтгэлгээтэй холбох үйл ажиллагаа явуулах болж, үүнийхээ үр дүнд 1922 онд "Аристотелийн тухай феноменологи интерпретаци" гэдэг зохиол бичсэн байна. Тэрээр энэ зохиолыг бичихдээ Геттинген юм уу Марбургт профессор болох найдвар тавьсан аж. 1923 онд Э.Гуссерлийн зуучлалтайгаар М.Хайдеггер Марбургийн их сургуулийн профессор болжээ. Тэрээр энэ их сургуульд ажилласан 1923-1928 онууд бол М.Хайдеггерийн сэтгэлгээний анхны төлөвлөлийн жилүүд байсан гэж судлаачид тогтоосон юм. Энэ хугацаанд М.Хайдеггер ялангуяа Аристотелийн философид шинжилгээ хийснээрээ дундад зууны ертөнцийг үзэх үзлийн, тухайлбал схоластик тогтолцооны феноменаль суурийг илрүүлэх зорилт тавихад хүрсэн аж⁴ (см. об этом: С.Н.Ставцев. Введение, гл.1). Тэгээд: Аристотелийн философи дахь "субъектив чанарын шууд амьдрал" бол тийм феноменаль суурь мөн гэсэн дүгнэлтэнд М.Хайдеггер хүрсэн байна. Чухамхүү эл дүгнэлт аваас М.Хайдеггерийн философийн анхны төлөвлөлийн шийдвэрлэх зүг чиг болж өгчээ.

М.Хайдеггерийн арга зүйн хувьд тийнхүү олзуурхсан "Аристотелийн философи дахь субъектив чанарын шууд амьдрал" гэж юу вэ? Үүнд хариулт болох зүйлийг "Метафизик" хэмээх нэр бүхий Аристотелийн бүтээлээс М.Хайдеггер "Метафизикийн удиртгал" номондоо дурдсан юм. Үүнд, Аристотелийн энэ бүтээлд "байгаа", "ахуй" гэдэг хоёр ойлголтыг ялган авч үзсэн байдаг.⁵ (См. об этом: Аристотель. Метафизика.-Аристотель. Сочинения в четырех томах. Том 1, М., 1976, с. 82) Аристотель: "байгаа бол олон аргаар хэлэгдэгч мөн" гэсэн тодорхойлолт томъёолсон байдаг. Тэгээд байгаагийн 4 төрөл (хэлэгдэгч) байдаг гэсэн ангилал гаргажээ. Тэдгээр нь⁶ (См. об этом: М.Хайдеггер. Введение в метафизику. СПб., 1997, с.30). 1/ирэхгүй (нэмэгдэхүй); 2/ үнэн; 3/ категориуд; 4/ бололцоо ба бодит байдал зэрэг⁷ (там же) юм.

Энэ ангиллын төрлүүдэд (хэлэгдэгчүүд) субъектив чанар чухал ач холбогдолтой гэж Аристотель үзэж байсныг М.Хайдеггер өөрийн шинжилгээгээр илрүүлжээ. Энэ бол Аристотелийг шинээр ойлгон гайлбарлах талаархи М.Хайдеггерийн чухал гавъяа болж өгдөг.

Аристотель байгааг ахуйгаа ялгаж байсан тухай М.Хайдеггер дурдсан. Тухайлбал "байгаа бол ахуйг эзэмддэг" гэж Аристотель бичснийг М.Хайдеггер дурдсан юм.

"Байгаа", "ахуй" гэдэг хоёр нэр томъёоноос утгыг Аристотель тийнхүү ялгасныг М.Хайдеггер өвлөсөн байна. Энд М.Хайдеггер уг хоёр нэр томъёоны утгыг обьективизмын үүднээс биш, харин субъективизм, феноменологийн үүднээс ойлгосон юм. Үүнийг нотлох нэг зүйл дурдахад М.Хайдеггер байгаа бол өөрийнхөө ахуйд хамаарч, ахуйдаа даатгагдагч⁸ (см. об этом: М.Хайдеггер. Бытие и время. М., 1997, с.41-42) гэсний зэрэгцээ ахуй бол байгаад өөрт нь холбогддог тийм үйл хэрэг мөн⁹ (см. об этом: там же) гэж бичсэн аж. Ингэхдээ тэрээр "ахуй", "байгаа" гэдэг нэр томъёонуудыг юмсын ахуйг авч үзсэн субъектийн оюуны бүтээл болж буй категорийн утгаар биш, харин энэ-ахуйн экзистенциалууд (өөрөөр хэлбэл ахуйг асуугчийн өөрийнх нь оршихуйн аргууд)-ын утгаар хэрэглэсэн аж.

Ийнхүү М.Хайдеггерийн фундаменталь онтологи бий болоход Аристотелийн философийн шийдвэр, хариулт нь биш, харин ахуйн утга учрын тухай асуулт нь хөтөч болж өгдөг байна.¹⁰ (см. об этом: Н.А. Гучинская. Стрекало вопроса (вместо предисловия).-гл.III-У.-М.Хайдеггер. Введение в философию. СПб., 1997).

М.Хайдеггер эртний Грекийн философич Аристотелийн философи үзлийг феноменологи аргын үүднээс шинжилсэн төдийгүй феноменологи сургаалд өөрт нь философи анализ хийсэн. Тийм анализынх нь үр дүн нь "Цаг хугацааны тухай ойлголтын түүхэнд холбогдох удиртгал санаанууд" гэдэг бүтээл юм. Энэ бүтээл бол тэрээр 1925 онд Марбургийн их сургуулийн зуны семестрт "Цаг хугацааны тухай ойлголтын түүх" гэдэг хичээл дээрээ уншсан лекцүүдийнх нь эмхтгэл мөн.

Би энэ өгүүлэлдээ "Цаг хугацааны тухай ойлголтын түүхэнд холбогдох удиртгал санаанууд" гэдэг М.Хайдеггерийн зохиолыг нэлээд чухалчлан авч үзэж байгаа нь түүний нийтлэгдсэн хугацааг төдий биш, харин өөр хоёр нөхцлийг илүү иш үндэс болгож байгаа юм. Үүнд, нэгдүгээрт, энэ зохиол бол М.Хайдеггерийн "Ахуй ба цаг хугацаа" гэдэг түүний үндсэн бүтээлийнх нь гол гол үзэл санааны жинхэнэ эхлэл болсон гэж судлаачид үздэг. Хоёрдугаарт, М.Хайдеггер энэ зохиолдоо Э.Гуссерлийн феноменологийг нягтлан шинжилж, зарим чухал баримтлалыг нь (өмнө дурдсанчлан) арга зүйн хувьд хүлээж авснаа тод илэрхийлж, үүний зэрэгцээ тэрээр (М.Хайдеггер) өөрийн сэтгэлгээний онцлогийг товойлгон харуулсан гэж судлаачид бичдэг юм. М.Хайдеггерийн дурдан буй зохиолын төдийгүй түүний анхан үеийн

философи анализын хамгийн түлхүүр ойлголт нь "Dasein" хэмээх категори юм.

Үгийн гарлыг нь авч үзвэл М.Хайдеггерийн философи дахь "Dasein" гэдэг нэр томъёо хоёр үгнээс бүтэж буй. Үүнд, "sein" гэдэг нь "байх", "орших" гэсэн утгатай юм. М.Хайдеггерийн философид утгаар тэр үг бол юмсын объективчлогдсон "байдгийг" биш, харин хувь хүний "би байдгийг" илэрхийлдэг утгатай юм. Харин "Да" гэдэг үг нь "энд", "одоо" гэсэн тухайн агшны философи утгыг илэрхийлдэг байна.

Энэ категорийг Оросын өөр өөр орчуулагч нар ялгаатай орчуулж иржээ. Тухайлбал: "бытие-вот"¹¹ "присутствие"¹² "сиюбытность"¹³, "вот-бытие"¹⁴ гэх мэт.

Манайд Dasein гэдэг М.Хайдеггерийн нэр томъёог олон ном зохиолд латин үсгийн бичлэгээр нь орчуулахгүйгээр хэрэглэж иржээ. Харин орчуулсан тохиолдолд зарим номонд "энд-ахуй" гэж явжээ¹⁵ (жишээ нь: Философи. Сурах бичиг. УБ., 2002, 182 дахь талаас үүнийг үзнэ үү).

Энэ өгүүлэлд нэлээд тохиолдолд латин бичлэгийг орчуулалгүй явсан болно. Хэрэв орчуулъя гэж бодвол "вот-бытие" буюу "энэ-ахуй" гэдэг орчуулгаар явах нь зүйтэй санагдлаа. Энэ нь дараахь хэд хэдэн шалтгаантай. Үүнд: М.Хайдеггерийнхаар Dasein бол ямар нэг агуулгат зүйл, субстанции биш, харин тэр нь тухайн цаг хугацааны туршлага, өөрөөр хэлбэл тухайн одоогийн хугацааны агшны ирэхүй мөн. Үүнийг үндэслэсэн нэг санааг М.Хайдеггераас иш татъя. Тэрээр "Цаг хугацааны тухай ойлголтын түүхэнд холбогдох удиртгал санаанууд" гэдэг бүтээлдээ бичихдээ: энэ-ахуй бол өөрөө өөрийнхөө төлөөх "энэ" мөн. Энэ нэр томъёог бид ашиглаж буй үед "энэ байх" бол "энд тэнд" үүсдэг, тохиолддог юмыг биш, харин энэхүү "энэ" нь өөрөө байхыг илэрхийлдэг. "Энэ"-ийн ийм шинж нь байгаагийн ахуйн аргад оршдог бөгөөд түүний бүтцийг ертөнцийн нээгдэгч шинж бүрдүүлж, тэр нь бас ертөнц-дэх-ахуйн өөрийнх нь нээгдэгч шинжийг агуулдаг гэжээ¹⁶.

Хоёрдугаарт, М.Хайдеггерийнхаар Dasein бол битүү түгжигдмэл биш, харин өөрийгөө байгаад (сущее) өөрийгөө илрүүлэн нээх замаар өөрөө өөрийгөө байнга даван туулж байдаг. Өөрөөр хэлбэл Dasein бол ахуй мөний хувьд цаг хугацаанаас гадуур, салангид байдаггүй бөгөөд эсрэгээр нь хэлбэл цаг хугацаа бол ертөнцөд урьд нь ямагт ирэгч ахуй болох байгаагийн илрэл мөн. Dasein бол тийнхүү ямагт байвч объектив биш цаг хугацаа биш, өөрөөр хэлбэл ахуйн тухайн агшны цаг хугацаа, бас өөрөөр хэлбэл тухайн агшны цаг хугацаагаар тодорхойлогдогч ахуй мөн. Энд ярьж буй ахуй бол

сонгодог онтологит ярьдаг ямар нэг субстанции биш, харин тухайн цаг хугацааны агшнаар "би"-гийн оршихуй тодорхойлогдохуй мөн. "Ертөнц-дэх-ахуй болох, холтгож-ойртгодог ахуй болох энэ-ахуйн ахуй бол энэхүү "энэ" өөрөө мөн. Энэ-ахуй болох тийм төрлийн байгаа бол ямагт анхнаасаа өөрийнхөө "энэ"-ийг авч явж, ийм байдал нь нээлттэй байх ерийн бололцоог ертөнцөд анх удаа өгдөг" ¹⁷ (там же, с.267) гэж М.Хайдеггер бичсэн байдаг. Тийнхүү энэ-ахуй бол хөдөлгөөнгүй, субъектив субстанции биш, харин өөрчлөлт ба ирэлт, Би-гийн ертөнцөө нээх хандлага мөн. Тийм учраас "хэн нэгний" тухай хэлэгдсэн байгаагаас юу мөрдөгдөх вэ? гэвэл, нэн түрүүнд энэхүү "энэ" бол Бусад "энэтэй" хамт байдаг зүйл, өөрөөр хэлбэл олон нийт рүү хандлагат "энэ" мөн гэдэг санаа мөн" ¹⁸ (см.:там же, с.267).

М.Хайдеггерийн боловсруулсан бусад онтологи ойлголт нь Dasein-ний бүтцийг бүрдүүлэгч жич жич элементийг илрүүлэх зорилготой байдаг.

Э.Гуссерлийн феноменологийг М.Хайдеггер нягтлан судалсныхаа үндсэн дээр: аливаа феноменологи тоочилт бол тоочигдож байгаа юмын өгөгдөх арга зүйн зөв хэрэгслийг заахаас эхлэх ёстой гэсэн дүгнэлт хийсэн байна. Өөрөөр хэлбэл туршлагын эхлэл талбарыг заах явдал бол феноменологийн чухал зарчим байх ёстой гэж М.Хайдеггер үзсэн байна. Учир нь, туршлага бол феноменологи шинжтэй байх ёстой. Феноменологи туршлага бол байгаль ёсны туршлага мөн бөгөөд түүнийг тээгч нь байгаль ёсны энэ-ахуй (Dasein) мөн.

Байгаль ёсны туршлагын дээр дурдсан маягийн аливаа онцлог бол зөвхөн тодорхой нөхцөлд арга зүйн зохих ач холбогдолтой байдаг. Өөрөөр хэлбэл энэхүү феноменологи туршлагын бусад хэлбэрт, жишээ нь материализм ба янз бүрийн шинжлэх ухааныг боловсруулдаг туршлагад эсрэгцүүлэн тавьж байгаа үед сая арга зүйн ач холбогдолтой байна гэж М.Хайдеггер үзсэн байна. Ийнхүү тэрээр байгаль ёсны туршлагын тухай ойлголтыг "интенциональ чанар" гэдэг Э.Гуссерлийн феноменологи ойлголтын дагуу боловсруулсан аж. Тухайлбал мэдрэгдэгч матери ба субъектийн биет үйл ажиллагаа зэргийг хүлээн зөвшөөрөх үндсэн дээр утгын тухай асуудлыг авч үздэг янз бүрийн онолыг М.Хайдеггер шүүмжлээд бичихдээ: "...феноменологи утгын үүднээс хандвал түүнчлэн юмыг сонсох нь ярианы өнгө аяыг жирийн нэг мэдэрч, авиаг дуулахаас илүү анхдагч юм. Түүнчлэн юмыг сонсох нь ойлгон сонсохуй бөгөөд өөрөөр хэлбэл бид "анх, бүхнээс өмнө" зүгээр нэг бөөн шуугиан чимээнийг биш, харин мотор, трамвай, мотоциклийн тачигнааг, жагсаалын дууг, хойноос үлээх салхийг сонсдог. "Цэвэр чимээ" маягийн ямар нэгэн юмыг "сонсохын" тулд маш

хиймэл, түвэгтэй зохиомжийг урьдчилан хүлээж авах ёстой. Гэхдээ бид нэн түрүүнд чухамхүү мотоцикл, машин гэх мэтийг сонсдог (энэ нь угтаа маш этгээд дуулддаг) баримт бол ертөнц дэх чухамхүү бидний хамгийн ойрын ертөнцөд бид аль хэдийнээс ертөнцтэй өөртэй нь харьцдаг болохоос янз бүрийн "сэрэлтэй" тийм биш гэдэг феноменологи батаалгааг бидэнд өгдөг.¹⁹(См. об этом: Мартин Хайдеггер. Пролэгомены к истории понятия времени. Пер. с нем. Е.В.Борисова. М., 1998, с.230)

М.Хайдеггер байгаль ёсны туршлагад өгөгдсөн "хүрээлэн буй ертөнцийн юм"-ыг тоочин илэрхийлэхдээ мэдрэгдэгч "перцептив" үйл явцад хамаарах онолын загварт түүнээ сэргүүлэн тавьсан байна. Үүнд: "... танин мэдэхүйн юм уу психологийн аливаа онолын үүднээс хандвал байгалийн юмс ба хүрээлэн буй ертөнцийн юмсыг ингэж тоочин илэрхийлэх нь маш гэнэн, иймээс шинжлэх ухаан ч биш санагддаг. Яагаад гэвэл би эхлээд харж буй, жич утгаараа нүдээрээ харж буй юм бол өнгө будагтай толбо төдий зүйл мөн. Үүнд: эхлээд би зөвхөн өнгөний сэрэлтэй байж гагцхүү дараа нь энэхүү толбондоо бусад бүх зүйлийг цомхтгодог" ²⁰ там же, с.43-44 М.Хайдеггерийн өөрийнх нь бичснээр "би харж байна" хэмээн бид ярихдаа "харах" хэмээх үгийг харааны сэрлийн явцуу утгаар биш, харин "өгөгдэхүүнийг жирийн танин мэдсэн" утгаар л ойлгодог байх ёстой.²¹ (см. об этом: там же, с.44)

Гадаад ертөнцийн юмыг тоочин илэрхийлдэг танин мэдэхүй бол арга зүйн хувьд маш гэнэн юм гэдэг эл үзлийг М.Хайдеггер "эпохе" гэдэг Э.Гуссерлийн зарчмаас гаргаж авсан байна. Энэ зарчмыг бас урьдчилсан нөхцөлгүйн зарчим гэж Э.Гуссерль нэрлэдэг байжээ. Хэрвээ энэ зарчмыг баримталбаас ямар ч шинжлэх ухааны ямар ч сайн үр дүн бол феноменологи нотолгоонуудын үндэслэл байж чаддаггүй. Гэхэдээ Э.Гуссерлийн боловсруулсан урьдчилсан нөхцөлгүйн зарчимд М.Хайдеггер шинэ санаа оруулжээ. Үүнд: Э.Гуссерлийн хувьд байгаль ёсны туршлага "өөрөөр хэлбэл ухамсар дахь байгаль ёсны зохиомж" бол хамгийн аюултай (нэн тэргүүнд натуралист шинжтэй) урьдчилсан нөхцлүүдийн ундарга болж, харин судалгаа урьдчилсан нөхцөлгүй байх нь өөрийн гэсэн ухамсар бүхий феноменологич хүний маш "хиймэл, жинтэй төөрүүлэгээнүүд"-ийн тусламжтайгаар хэрэгждэг гэж үзсэн бол М.Хайдеггерийн хувьд "байгаль ёсны", "урьдчилсан нөхцөлгүй" гэдэг хоёр тодотгол ижил утгатай байдаг.

Байгаль ёсны туршлагын зарим чухал онцлогийг илрүүлэн тайлбарлахад М.Хайдеггер "Цаг хугацааны тухай ойлголтын түүхэнд холбогдох удиртгал санаанууд" зохиолдоо нэлээд анхаарал тавьсан байдаг.

Ингэхдээ ертөнцийн ба Ондоо хүний өдөр тутмын туршлагыг байгаль ёсны туршлагатай харьцуулан авч үзсэн байдаг. Тэгээд байгаль ёсны туршлагад дараахь зарим онцлог шинж байдгийг тодруулан авч үзжээ. Үүнд: үл анзаарагдах шинж (сэдэвгүй шинж, судлагдахуунтай шинж), шууд шинж, өөрөө ойлгогдох шинж, үл тайлагнадаг шинж (рефлексив биш шинж) зэрэг юм. Тэдгээр шинж бүрийн онцлогийг М.Хайдеггер дараахь байдлаар тайлбарлажээ.

-Байгаль ёсны туршлагын өгөгдөхүүнүүд бол үл анзаарагдмал байдаг. Учир нь, байгаль ёсны туршлага бол энэ-ахуй холбогдох юмстайгаа шууд авцалдсан оршихуй мөн. Өөрөөр хэлбэл байгаль ёсны туршлага доторхи юм бол энэ-ахуйтай харьцуулахад ямар нэг гадаад юм биш, харин түүний ахуйд шууд хамрагдсан байдаг. Тийнхүү байгаль ёсны туршлагын үүднээс юмс бол туршлагын сэдэв, судлагдахуун болдоггүй.

-Байгаль ёсны туршлага шууд шинжтэй гэдэг нь юу гэсэн утга вэ? гэвэл энэ туршлага янз бүрийн дамжлага, чармайлтыг үл шаарддаг гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл байгаль ёсны туршлага үүсмэл шинжгүй бөгөөд тэр нь туршлагын нийт шаталсан байгууламжийн суурь статус мөн. Өөрөөр хэлбэл энэ-ахуйн (Dasein-ий) байгаль ёсны туршлагын агуулга ямар нэг бусад тайлбараар дамжиж биш, мөн мэдрэгдэгч "матери" зэргийг шаардаж биш, харин аяндаа өөрөө ойлгогддог тодорхой утгатай байдаг.

-Энэ-ахуйн байгаль ёсны туршлагад үл тайлагнадаг шинж буюу рефлексив биш шинж яаж илэрдэг вэ? гэвэл энэ-ахуй нь өдөр тутмын оршихуйдаа аль нэг Би-биш, Ондоо хүмүүс, хүрээлэн буй ертөнц зэргээс ялгарагч биш байдаг тул өөрийгөө ухамсарлахуй (рефлектэй) байдаггүй. Энэ тухай тэрээр өгүүлэхдээ **"нэн түрүүнд энэ-ахуй бол өөрийн биш дотор амьдардаг. Нэн түрүүнд өдөр тутмын байдалд чухамхүү өөрийн ертөнц ба өөрийн энэ-ахуй бол хамгийн алс зүйл мөн; Ондоо хүмүүстэй хэн нэгэн оршигч чухам тийм ертөнц эхлэн өгөгдөж, чухамхүү тэр ертөнцөөс улбаалан өөрийн ертөнц рүү их бага ямар нэг хэмжээгээр тууштай урган орж болно"**²²(там же, с.259-260).

Энэ-ахуйн тухай М.Хайдеггериин үндэслэл нь "Би"-гийн тухай түүний өөрийнх нь онтологи үзлийг үгүйсгэж байгаа мэт сэтгэгдэл төрүүлж магадгүй байдаг. Харин нарийвчлан авч үзвэл Би ба рефлекс бол субъект бодитой байхыг хангагч гоц үзэгдлүүд, ингэхдээ өдөр тутмын судлагдахуунтай биш, субъекттэй биш, рефлексив биш туршлагын үндсэн дээр бололцоотой байдаг тийм гоц үзэгдлүүд мөн гэснээрээ М.Хайдеггериин феноменологи нь түүний онтологи баримтлалыг нь давхар үндэслэдэг байна.

М.Хайдеггерийн бүтээлүүдийн нийтлэгдсэн дарааллыг нь биш, харин тэрээр арга зүйн сонголтоо хийснээ илэрхийлсэн далайцыг нь үндэс болговол түүний "Цаг хугацааны тухай ойлголтын түүхэнд холбогдох удиртгал санаа" зохиолынх нь дараа 1929 онд хэвлүүлсэн "Кант ба метафизикийн асуудал" гэдэг бүтээлийг нь авч үзэхийг тохиромжтой гэж бодож байна. Угтаа энэ зохиол бол М.Хайдеггерийн бүтээлийн анхан үеийнх нь үндсэн зохиол болох "Ахуй ба цаг хугацаа" гэдэг номынх нь нэг хэсэг аж.


М.Хайдеггер энэ бүтээлдээ дараахь зорилтууд тавьснаа өөрөө дурдсан юм. Үүнд: ²³(см. об этом: Мартин Хайдеггер. Кант и проблема метафизики. М., 1997, с.1):

1/ Кант цэвэр оюун ухааныг, өөрөөр хэлбэл ямар нэг юмыг туршлагатай холбоогүйгээр (априори байдлаар) танин мэдэх чадварыг шүүмжилсэн нь уламжлалт метафизикийг эвдсэн тийм метафизикийг үнэдслэсэн байдал мөн.

2/ Кант цэвэр оюун ухааныг, шүүмжилснийг М.Хайдеггер тайлбарласан нь тэрээр (М.Хайдеггер) өөрийн метафизикийн асуудлыг фундаменталь онтологийн асуудал болгож илэрхийлсэн байдал мөн. "Фундаменталь онтологи бол төгсгөлт амьтан болох хүний онтологи аналитик мөн бөгөөд тэр нь "хүний уг чанарт" чухал фундаментийг метафизик бэлтгэх ёстой" ²⁴ (там же). Өөрөөр хэлбэл фундаменталь онтологи бол хүн гэж юу вэ? Гэдэг асуултыг ямар зорилгоор, ямар байдлаар, ямар хүрээнд, ямар болзолтойгоор тавих ёстойг заана ²⁵ (см. об этом: там же) гэж М.Хайдеггер бичжээ. Тийм учраас М.Хайдеггерийн метафизик (онтологи) бол бэлэн барилга биш, харин хүн тус бүр дэх байгаль ёсны чадвар мөн ²⁶(см. об этом: там же).

М.Хайдеггерийн тайлбараар Аристотелиос хойш Өрнөдөд бий болсон метафизикийн хөгжил бол Аристотелийн бий болгосон хуурамч онтологи тогтолцоог хүлээн авч үргэлжлүүлсний үр дүн биш юм. Гэвч үүний зэрэгцээ орчин үеийн Өрнөдийн метафизик бол Платон, Аристотель нарын дэвшүүлсэн гол гол асуудлыг орхигдуулсан аж. Тодруулж хэлбэл Өрнөдийн метафизик нь Аристотелийн онтологийн объективизмыг дагаагүй нь зүйтэй болсон авч тэр онтологид субъектив чанарын амьдралын асуудал шингэмэл байдгийг анхаарахгүй явж ирлээ гэж М.Хайдеггер үзсэн байна.

М.Хайдеггер эртний грекчүүдийн онтологи сэтгэлгээнд өгсөн ийм арга зүйн үнэлгээгээ христос шашны метафизикт хамаатуулсан гэж болмоор байдаг. Тэрээр ертөнц, хүн хоёр хэрхэн анх үүссэн тухай Библийн



тайлбарын дагуу өгүүлэхдээ: метафизикийн агуулгын нэг чухал уг сурвалж нь христос шашны философи гэж үзэх ёстой гэсэн байна. Үүнд, христос шашны метафизикийн үүднээс авч үзвэл бурхан тэнгэрлэг биш байгаа бүхэн бол бүтээгдмэл байдаг. Ийм учраас христос шашны философийн үүднээс байгаагийн бүхэл нь бурхан тэнгэр, байгаль, хүн гурав гэж хуваагддаг. Бүтээгдмэлүүд дотор хүн онцгой байдалтай. Учир нь, байгаа бүхэн бол хүний сүнсийг аврахад, сүнсний оршихуй мөнх байхад үйлчилдэг хэмээн М.Хайдеггер дүгнэсэн байна. Түүний эл дүгнэлт нь хүний энэ-ахуйг тэрээр философийнхоо төвд тавих нэн чухал нэг зүг чиг болж өгчээ.

Байгаа тийм гурван салбарт хуваагддаг нь теологи (шашны онол), космологи (орчлонгийн онол), психологи (сэтгэлийн онол) гэсэн мэдлэгийн гурван салбар үүсэхэд хүргэсэн гэж М.Хайдеггер үзжээ. Уламжлалт шашныг метафизикийн энэ гурван салбарыг М.Хайдеггер "*metaphysica specialis*"²⁷(см. об этом: Мартин Хайдеггер. Кант и проблема метафизики. М., 1997, с.5) гэсэн юм. Тэдгээрийг салбар метафизик гэж нэрлэж болмоор юм. Үүний зэрэгцээ М.Хайдеггер "*metaphysica generalis*" бол ертөнцийн тухай христос шашны тайлбарт байдаг гэж үзсэн²⁸(см. об этом: там же). Түүнийг ерөнхий метафизик гэж нэрлэж болмоор байна. Улмаар М.Хайдеггер чухамхүү энэхүү ерөнхий метафизик бол "ерөөсөө" байгааг л судлах зүйлээ болгодог гэж бүхэлдээ Библийн агуулгаар тодорхойлогддог тайлбарлажээ. Ингэж үзвээс ерөнхий метафизик бол онтологи байж хуизрдаг.

Ийнхүү М.Хайдеггерийн тайлбараар уламжлалт метафизикийн агуулга бүхэлдээ Библийн агуулгаар тодорхойлогддог.

И.Кантын субъективизм нь түүний боловсруулсан гносеологийнх нь арга зүйн үндэс болж өгсөн бол М.Хайдеггер түүнийг нь судалсны үндсэн дээр субъективизмыг феноменологийн үүднээс хүлээж аваад улмаар өөрийн боловсруулсан энэ-ахуйн тухай сургалынхаа арга зүйн үндэс болгосон ажээ.

М.Хайдеггерийн философи үзлийн төлөвшилийн анхны үеийнх нь үндсэн бүтээл бол түүний "Ахуй ба цаг хугацаа" гэдэг зохиол мөнийг өмнө дурдсан билээ. Тэрээр энэ бүтээлээ бүр 1925 онд бичсэн байсан аж. Тэгээд түүнээ 1927 онд хэвлүүлэхдээ Э.Гуссерльд "гүн хүндэтгэл, эв найр" илэрхийлж дурсгал болгож байгаагаа өгүүлсэн аж. Гэвч Э.Хайдеггер энэ номыг үл таашаасан байна. Учир нь, "феноменологи бол би, тэгээд Хайдеггер мөн" гэж итгэн дурдаж байсан²⁹(см. об этом: В.Н.Семенова. Хайдеггер.-Постмодернизм. Энциклопедия. Мн., 2001., с.924) Э.Гуссерлийн хувьд М.Хайдеггер байгаагийн ахуйн тухай асуудлыг философийнхоо

хамгийн чухал асуудал болгосон нь феноменологи судалгааг дараахь үндсэн хоёр байдлаар гуйвуулсан аж. Үүнд нэгдүгээрт, феноменологи судалгаа бол М.Хайдеггерийн ойлгосончлон зэвхэн энэ-ахуйн биш, харин аливаа байгаагийн эзэмддэг шинжүүдийг илрүүлдэг байх ёстой. Хоёрдугаарт, феноменологи судалгаа бол байгаа (юмс), ухамсар хоёрын харилцааг авч үзэн тодорхойлох ёстой, өөрөөр хэлбэл тухайн байгааг танин мэдсэн байхын тулд ухамсрын ямар ямар үйлдэл чухал буйг тоочин илэрхийлэх ёстой гэж Э.Гуссерль үзэж байв.

Харин М.Хайдеггер болохоор арга зүйн хувьд юу гэсэн байр суурь илэрхийлсэн бэ гэвэл байгаагийн талаархи феноменологи анализ аваас Би-гийн ахуйн арга, юмсын ахуйн арга хоёрын мөн чанарлаг ялгааг үл олж хараад улмаар эндээсээ Би-гийн ахуйг экзистенциаль онтологийн үүднээс шинжлэхийг орхигдуулж байна гэж тэрээр үзсэн аж.

Гэхдээ энэ өгүүлж буй зүйлс бол М.Хайдеггер "Ахуй ба цаг хугацаа" бүтээлдээ феноменологиос арга зүйн хувьд бүрэн татгалзсан гэсэн санааг биш, харин феноменологийг чухамхүү өөрийн боловсруулж буй фундаменталь онтологийнхоо л арга зүй болгох ёстой гэж М.Хайдеггер үзснийг илэрхийлж буй болно. М.Хайдеггер "Ахуй ба цаг хугацаа" зохиолынхоо агуулгыг философийн антроплогийн нэг хувилбар биш, харин энэ-ахуйн тухай нарийн нягт феноменологи шинжилгээ (аналитик) мөн гэж онцлон өгүүлж байсныг энэ дашрамд дурдъя ¹⁰(см. об этом напр.: Мартин Хайдеггер. Кант и проблема метафизики, с.1).

Хүн бол ахуйг ойлгохыг эзэмддэг ганц байгаа мөн гэдэг үндэслэлийг М.Хайдеггер энэ-ахуйг судлах угтвар санаа болгосон аж. Тэгээд "энэ-ахуй бол ахуйг ойлгогч байгаа мөн" гэдэг философи санааг "Ахуй ба цаг хугацаа" бүтээлдээ тэрээр сурталчилжээ. М.Хайдеггер энэ-ахуйг: 1/ "дахь (дэх)-ахуй"; 2/ ертөнц байдалт; 3/ энэ-ахуй "ертөнцөд" "нээгдсэн мэт" тийм байдалт гэсэн гурван талтайгаар авч үзсэн байна. "Нээгдсэн байдал" нь энэ-ахуйн уг чанарыг илрүүлэгч гурван аргатай аж. Тэдгээр нь: 1. "Араншин". Энэ бол энэ-ахуйг ертөнц лүү "хаягдсан" болохыг илрүүлэхүй мөн. 2. "Ойлгохуй". Энэ бол энэ-ахуйг "төсөл" болгон илрүүлэхүй мөн. 3. "Яриа". Энэ бол энэ-ахуйг "уналт" болгон илрүүлэхүй мөн. Эдгээр дараалсан бодгаль экзистенциаль эгнээнүүдээс энэ-ахуйн бүхэллэг бүтэц тогтдог хэмээн М.Хайдеггер тайлбарлажээ. Энэ бүхэллэг бүтэц бол "санаашрал" мөн хэмээн М.Хайдеггер томъёолоод, тэр нь дараахь гурван элементтэй байдаг гэжээ. Үүнд: 1."Ертөнц-дэх-ахуй". Санаашралын энэ элемент бол Би-гийн ахуй,

ертөнц хоёр, объектив зүйл, субъектив зүйл хоёр салшгүйн илэрхийлэл мөн.

2."Урагшаа үймэн гүйхүй". Энэ бол бэлэн, биет-ахуйгаас Би-гийн ахуй ялгаатай байдгийг онцлон илэрхийлдэг ойлголт аж. Үүнд, Би-гийн ахуй бол ямагт өөрөөсөө "зугтан", урагшаа тэмүүлж байдгаас ямагт өөрийгөө төлөвлөгч ахуй буюу өөрийн бололцоо мөн. Иймд хүний биеийн байгаа орон зайн цэг, "физик" цаг хугацааны агшинд Би-гийн ахуй оршдоггүй.

3.Санаашралын гурав дахь элемент нь "дотсод ертөнцийн-юмын-үеийн-ахуй" мөн. Энэ элемент бол Би "төгсгөлт" амьдралдаа өөрийн дагуул болсон юмсад харьцдаг харьцаа мөн. Тэдгээр юмс нь бэлэн, биет шинжтэй биш, харин Би-г аялдан дагаж, түүний дотоодод байдаг.

Ийнхүү энэ-ахуйн дотоод бүтцийнх нь элементүүдийг тооцох үндсэн дээр түүнийг энэ-ахуйг тодорхойлбол тэр нь "ямагт аль хэдийн -өөрийгөө-урагшлуулах-ертөнцөд-ахуйн утгаар-дотоод ертөнцийн-үеийн юм" мөн.

М.Хайдеггер санаашралын гурван элементийн тухай ярьсан нь угтаа энэ-ахуйн цаг хугацааны модусууд аж. Үүнд, "ертөнц-дэх-ахуй" нь өнгөрсний модус, "урагшаа үймэн гүйх" нь ирээдүйн; "дотоод ертөнцийн-юмын-үеийн-ахуй" нь одоогийн модус ажээ. Ийнхүү М.Хайдеггерийн ярьдаг өнгөрсөн, одоо, ирээдүй гурав бол физик ба философид ярьдаг объектив цаг хугацааны гурван хэмжүүрээс үндсээрээ ялгаатай. Түүнийхээр өнгөрсөн бол нэгэнт байхгүй, "ард хоцорсон" юм биш, харин байнга ирэн, өөрийгөө одоо ба ирээдүйн аль аль маягаар тодорхойлдог. Мөн нөгөө хоёр модусыг ч гэсэн ийм маягаар тайлбарлаж болдог. Тэгснээр "одоо" гэсэн эгшнүүдээс тогтсон нэг төрлийн шугамууд маягаар сэтгэгддэг физик, объектив цаг хугацаанаас эдгээр модус чанарын ялгаатай нь тодорч байх ёстой ажээ. Тэгээд М.Хайдеггер: өнгөрсний модус бол "баримт сэлтийн шинж", өөрөр хэлбэл хаягдмал шинж мөн. Одоогийн модус бол "юмс дахь сөнөх тавилангийн шинж", ирээдүйн модус бол бидэнд байнга нөлөөлж байдаг "төсөл, төлөвлөгөө" мөн гэжээ. Ийм үзлийн үүднээс хандвал цаг хугацааны экзистенциал цутгалан нь өнгөрснөөс ирээдүй рүү явдаг биш, харин ирээдүйгээс өнгөрсөн рүү чиглэлтэй байж таардаг. Өөрөөр хэлбэл энэ-ахуй өөрийнхөө цаг хугацааны шинжээрээ бол ирээдүйгээс өөрийгөө нээж, өнгөрснийгөө ил болгож, тэр өнгөрсөн нь ирээдүйтэй хамтаар энэ-ахуйг өнөө дотор идэвхжүүлж байдаг.

М.Хайдеггер ахуйн цаг хугацааны талаархи ийм ойлголттойгоо шууд холбоотойгоор Би-гийн орших тууштай ба тууштай биш аргын тухай ярьсан байна. Үүнд, цаг хугацааны ямар модус давамгайлж байгаагаас шалтгаалаад Би-гийн оршихуй тууштай юм уу тууштай биш байдаг.

Одоогийн модус давамгайлж байгаа үед тууштай биш ахуй оршин, "юмсын ертөнц" нь Би-гийн төгсгөл мөхлийг нь холтгодог. Тууштай биш оршихуйн үед Би өөрийгөө юмтай, бас аливаа дурын хүн бүртэй адилтган, өөрийгөө аль нэг хүнээр орлогдоно гэж үздэг. Аливаа өөрөө бол Бусдад хамаарч, Бусад нэг бүр нь үлдсэн Бусдыг оролдог. Ийнхүү субъект бол би өөрөө буюу хэн нэг хүн биш, бас бусдын нийлбэр биш, харин ямар нэг дундач, өөрөөр хэлбэл "Man" мөн. "Man" бол хэл, сэтгэхүй зэрэгт илэрдэг зан суртахууны нийтээр зөвшөөрдөг зохих зарчмууд мөн. "Man" бол Би-д дайсагнаж, чөлөөт үйл ажиллагаанд нь саад болж, Би-г эзэн биегүй болгодог.

Ийнхүү "Man" гэдэг ойлголт нь нийгэм, бие хүн хоёр эвлэршгүй зөрчилтэй байдаг гэсэн М.Хайдеггерийн үзлийн илэрхийлэл юм. Энэ зөрчлийг арилгая гэвэл Би-гийн ахуйг ирээдүйд шилжүүлэн, оршихуйн тууштай байдлыг "Man"-д хангах ёстой гэж М.Хайдеггер үзжээ.

"Тууштай оршихуй" бол Би өөрийнхөө түүхэн төгсгөлт шинжийг ухаарах байдал мөн. Энэ нь зөвхөн үхэл өмнө тулгарахад хэрэгждэг. "Man" бол үхлийг мэддэггүй бөгөөд учир нь, түүний ертөнц бол биегүй ертөнц мөн. "Man" бол Би-гийн ахуй өөрөөсөө зугтахуй юм. Хүн зөвхөн "экзистенциал айдсаа" мэдэрсэн үедээ тууштай биш оршихуйн хязгаараас мултардаг. Айдас бол Би-гийн ахуйн "үндсэн араншин" нь болж шинэ хэтийн төлөв болох үхлийг хүнд нээж өгдөг. Энд айдас бол эмпирик, бодит айдас биш, харин ямар нэг тодорхойгүй зовиур, гунихрал мөн.

М.Хайдеггер "экзистенци" гэдэг нэр томъёог С.Кьеркегорын философиос аваад: энэ-ахуй бол экзистенцид оршдог гэсэн. Гэхдээ М.Хайдеггерийн хувьд экзистенци дотор байгаль, хүний мөн чанар аль аль нь байдаг. "Экзистенци" бол төгсгөлтэй, үхэл рүү чиглэсэн байдгаараа тэсч ядсан шинжтэй байдаг. Хүнээс бусад нэг ч юм өөрийн төгсгөлийг, үхэхийг мэддэггүй учраас зөвхөн хүнд л юм, түүний ахуй цаг зуурын шинжтэй нь мэдэгдэж байдаг гэж бас өгүүлдэг. Энэ үндэслэлд хүний үйл ажиллагаа ухамсарт шинжтэй, тэр нь угтан харах чадварт үндэслэдэг гэсэн санаа шингэсэн байдгийн зэрэгцээ эцэс, төгсгөл бол, ахуйн үхлийн шийдвэрлэгч тал мөн гэдэг гутранги (пессимист) үзэл бас шингэсэн байдаг.

Үхлийн тухай М.Хайдеггерийн үзэл нь нийгмийн харилцаа биехүний чөлөөт үйл ажиллагаанд харшилдгийг тэрээр хэрхэн ойлгодгийг нь илтгэдэг.

Гэвч М.Хайдеггер 30-аад оны дунд үеэс хойш сэтгэлийн зовиурт элементүүдийг онтологичлон тайлбарладаг байр сууриа аажим аажмаар орхиж, оронд нь "ахуй", "юу ч биш", "дэлхийн", "орчлонгийн", "үндсэн ба

үндсэн бус", "далд ба ил" гэх мэт шидэт домэг зүйн утга нэлээд орсон ойлголтууд ашигладаг болжээ. Ингэхдээ метафизик сэтгэхүйг шүүмжлэх замаар энэ зорилтоо хэрэгжүүлж байв.

М.Хайдеггерийн хувьд метафизик бол сэтгэхүйн арга, философийн ойлголт төдий биш, харин хүн байгальтай болон бие биестэйгээ харьцах ага, сэтгэхүйн аргыг нэг хэсгээ болгодог тийм, түүхийн бүхэл бүтэн эриний тодорхой шинж мөн. Тэгээд тэрээр ийм үзлийнхээ үүднээс: метафизик бол ертөнцийг хүнд захируулах зорилго тавьдаг орчин үеийн шинжлэх ухаан, техникийн үндэс; ахуйг биш, харин юмыг авч үздэг "психологич" урлагийн үндэс; орчин үеийн шашингүйн чанарын "ариун ба ариуссан" бүгд алдагдахын үндэс мөн гэжээ. Түүнчлэн метафизик бол ахуйг мартсан, хотжиж, "олон түмэнлэг" болсон амьдралын хэв маягийн үндэс юм гэжээ.

М.Хайдеггерийн тооцоогоор метафизикийг даван туулья гол нь европын соёл дахь метафизик ойлгоцоор халагдсан анхдагч ахуйг сэргээх ёстой... тэр ахуй бол Сократ, Парменид нараас өмнөх үеийн грек хэлэнд тэмдэглэгдэж байсан ажээ. Гагцхүү хэл л ахуйн үнэнийг олж авах бололцоо өгнө. Хэл бол ахуйн сууц мөн.

Орчин үеийн хэл нь техникжиж, мэдээлэл дамжуулах хэрэгсэл боллоо хэмээн М.Хайдеггер бичжээ. Тэрээр хэлний үзэгдэлд хамаарах ийм үнэн баримтанд үндэслээд жинхэнэ хэл мөхөж байгаа тухай дүгнэлт хийжээ. Үүнд, орчин үед хэл жинхэнэ "яриа", "хэлэхүүн" мөний хувьд устаж байна. Үүний улмаас орчин үеийн хүн болон түүний соёлыг ахуйтай холбосон эцсийн холбоо үгүй болж, энэ соёлын амьдралын ундарга шавхагдаж, хэл өөрөө үхмэл болж хувирлаа. Иймд жинхэнэ ахуйг сэргээх гэвэл жинхэнэ хэлийг буцаан сэргээж, түүнийг "сонсох" явдал мөн. Иймд "ахуйн үнэнийг" нээдэг хэл гагцхүү яруу найрагчдын бүтээлд байдаг ажээ. Ялангуяа эртний Грекийн тийм "уг сурвалжуудад" нэвтрэх нь тэдгээрийн хэлийг "сонсож", үүний үндсэн дээр жинхэнэ ахуйг сэргээж болох аж.

* * *

М.Хайдеггерийн зохиолуудыг нягтлан судлах нь XX зууны томоохон сэтгэгчдийн нэг болох энэ хүний өөрийнх нь философи өвийг эзэмших үйл ажиллагаа мөн төдийгүй европын философийн түүхийг экзистенциалист байрнаас ойлгон ухаарах нэн чухал нэг ундарга юм.

Ашигласан ном зсхиол

¹ (см. об этом: Н.А.Гучинская. Вместо предисловия. Стрекало вопроса.-Мартин Хайдеггер. Введение в философию. Пер.с нем. Н.О.Гучинской. СПб., 1997, с.17)

² (Мартин Хайдеггер. О существе и понятии Аристотель "Физика". В-1. М., 1995, 30 дахь тал)

³ (см. об этом напр.: А.Михайлов. Вместо введения.- Мартин Хайдеггер. Работы и размышления разных лет. Пер. с нем. А.Михайлова. М., 1993, с. XXXI).

⁴ (см. об этом: С.Н.Ставцев. Введение, гл.1).

⁵(См. об этом: Аристотель. Метафизика.-Аристотель. Сочинения в четырех томах. Том 1, М., 1976, с.182)

⁶ (См. об этом: М.Хайдеггер. Введение в метафизику. СПб., 1997, с.30)

⁷ (там же)

⁸ (см. об этом: М.Хайдеггер. Бытие и время. М., 1997, с.41-42)

⁹ (см. об этом: там же)

¹⁰(см. об этом: Н.А. Гучинская. Стрекало вопроса (вместо предисловия).-гл.III-У.-М.Хайдеггер. Введение в философию. СПб., 1997).

¹¹ См об этом напр.: Время и бытие: Статьи и выступления: Пер с нем.-М., Республика, 1993

¹² См об этом.: Мартин Хайдеггер. Работы и мышления разных лет. Пер с нем. (Составл., переводы. Вступ. Статья, примеч. А.В.Михайлова. М., Издательство "Гносис", 1993)

¹³ См об этом.: Мартин Хайдеггер. Введение в метафизику. Перевод с немецкого Н.О.Гучинской. СПб., 1997

¹⁴ См об этом.: Мартин Хайдеггер. Прелегомены к истории понятия времени. Пер. Е.Борисова. Томск., 1998

¹⁵ (жишээ нь: Философи. Сурах бичиг. УБ., 2002, 182 дахь талаас үүнийг үзнэ үү).

¹⁶ См об этом.: Мартин Хайдеггер. Прелегомены к истории понятия времени. с.

¹⁷ (там же, с.267)

¹⁸ (см.:там же, с.267).

¹⁹(См. об этом: Марин Хайдеггер. Прологомены к истории понятия времени. Пер. с нем. Е.В.Борисова. М., 1998, с.283)

²⁰ там же, с.43-44

²¹ (см. об этом: там же, с.44)

²²(там же, с.259-260).

²³(см. об этом: Мартин Хайдеггер. Кант и проблема метафизики. М., 1997, с.1):

²⁴ (там же)

²⁵ (см. об этом: там же)

²⁶(см. об этом: там же)

²⁷(см. об этом: Мартин Хайдеггер. Кант и проблема метафизики. М., 1997, с.5)

²⁸(см. об этом: там же).

²⁹(см. об этом: В.Н.Семенова. Хайдеггер.-Постмодернизм. Энциклопедия. Мн., 2001., с.924)

³⁰(см. об этом напр.: Мартин Хайдеггер. Кант и проблема метафизики, с.1).